



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Арвайхээр сумын 14-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/88/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал  
Утас: 70323253      Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn  
Аудитын менежер: Д.Гансүх  
Утас: 70323833      Цахим хаяг: gansukh.audit@gmail.com  
Аудитор:              Ө.Ринчинмядаг  
Утас: 70323108      Цахим хаяг:  
rinchinmyadagu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	12
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Төлбөрийн акт .....	15
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

᠑᠐᠒᠐.᠐᠒.14 № 1᠙8  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРВАЙХЭЭР СУМЫН 14 ДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ю.МАНДАХ ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арвайхээр сумын 14-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арвайхээр сумын 14-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazartbaiguullagiin dotood barimt\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,281,850.00</b>	<b>46,920,435.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0.00</b>	<b>25,200.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	25,200.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>24,281,850.00</b>	<b>46,895,235.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>190,000.00</b>	<b>363,200.00</b>
35130	Эм боох материал	190,000.00	363,200.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>24,091,850.00</b>	<b>46,532,035.00</b>
35410	Бичиг хэргийн материал	0.00	683,400.00
35420	Аж ахуйн материал	0.00	129,100.00
35450	Барилгын засварын материал	0.00	1,112,500.00
35460	Хүнсний материал	0.00	951,235.00
35470	Бусад хангамжийн материал	24,091,850.00	43,655,800.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,011,350,209.28</b>	<b>1,006,200,376.75</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,011,350,209.28</b>	<b>1,006,200,376.75</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>947,499,542.62</b>	<b>942,525,710.12</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	909,106,043.00	921,106,043.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-7,492,550.36	-31,220,201.48
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	26,954,000.00	36,728,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-253,811.12	-8,391,075.70
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,635,000.00	30,505,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-449,138.90	-6,202,555.70
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>63,850,666.66</b>	<b>63,674,666.63</b>
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-29,333.34	-205,333.37
39303	Бусад биет бус хөрөнгө	63,000,000.00	63,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,035,632,059.28</b>	<b>1,053,120,811.75</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,035,632,059.28</b>	<b>1,053,120,811.75</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,035,632,059.28</b>	<b>1,053,120,811.75</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	63,000,000.00	63,000,000.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>972,632,059.28</b>	<b>990,120,811.75</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	972,632,059.30
51220	Тайлант үеийн үр дүн	972,632,059.28	17,488,752.45
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,035,632,059.28</b>	<b>1,053,120,811.75</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,063,861,043.00</b>	<b>439,137,705.47</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>909,106,043.00</b>	<b>16,897,362.47</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>909,106,043.00</b>	<b>16,897,362.47</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	909,106,043.00	10,948,562.47
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	5,948,800.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>154,755,000.00</b>	<b>422,240,343.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>105,525,000.00</b>	<b>373,105,400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	105,525,000.00	373,105,400.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,430,000.00</b>	<b>12,802,743.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	12,662,743.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	140,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>39,800,000.00</b>	<b>36,332,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,800,000.00	36,332,200.00
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>91,228,983.72</b>	<b>421,648,953.02</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>91,228,983.72</b>	<b>421,648,953.02</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>79,905,261.87</b>	<b>415,597,607.86</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>53,834,201.00</b>	<b>291,785,800.00</b>
210101	Үндсэн цалин	42,648,800.00	223,925,267.00
210102	Нэмэгдэл	10,826,447.00	48,428,633.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	358,954.00	19,431,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>6,715,499.15</b>	<b>38,922,512.84</b>
210201	Тэтгэврийн даатгал	4,655,708.47	27,273,374.31
210202	Тэтгэмжийн даатгал	538,344.14	3,032,854.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	430,672.93	2,322,306.17
210204	Ажилгүйдлийн даатгал	99,162.13	642,287.63
210205	Эрүүл мэндийн даатгал	991,611.48	5,651,689.83
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>8,788,578.00</b>	<b>29,462,243.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	195,147.00	2,192,328.00
210302	Түлш, халаалт	8,426,880.00	23,398,637.00
210303	Цэвэр, бохир ус	166,551.00	3,871,278.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,137,700.00</b>	<b>4,616,250.00</b>
210401	Бичиг хэрэг	979,000.00	1,612,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	213,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,158,700.00	1,789,750.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>28,000.00</b>	<b>9,891,165.00</b>

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,000.00	10,300.00
210502	Хоол, хүнс	0.00	9,429,065.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	451,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>176,450.00</b>	<b>1,986,500.00</b>
210604	Урсгал засвар	176,450.00	1,986,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>0.00</b>	<b>1,134,142.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,134,142.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,224,833.72</b>	<b>37,798,995.02</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	563,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	297,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,224,833.72	36,938,395.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,323,721.85</b>	<b>6,051,345.16</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>700,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	700,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>5,351,345.16</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	5,351,345.16
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,105,299.85	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>972,632,059.28</b>	<b>17,488,752.45</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>972,632,059.28</b>	<b>17,488,752.45</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	63,000,000.00	0.00	0.00	63,000,000.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	972,632,059.28	972,632,059.28
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	63,000,000.00	0.00	972,632,059.28	1,035,632,059.28
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	63,000,000.00	0.00	972,632,059.28	1,035,632,059.28
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.02	0.02
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	63,000,000.00	0.00	972,632,059.30	1,035,632,059.30
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	17,488,752.45	17,488,752.45
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	63,000,000.00	0.00	990,120,811.75	1,053,120,811.75

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	154,755,000.00	422,240,343.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	154,755,000.00	422,240,343.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	105,525,000.00	373,105,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	105,525,000.00	373,105,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,430,000.00	12,802,743.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдааг үй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	12,662,743.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,430,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	140,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,800,000.00	36,332,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,800,000.00	36,332,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	107,286,000.00	401,400,343.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	107,286,000.00	401,400,343.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,962,278.15	395,348,997.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53,834,201.00	291,811,000.00
210101	Үндсэн цалин	42,648,800.00	223,950,457.00
210102	Нэмэгдэл	10,826,447.00	48,428,643.00
210104	Урамшуулал	358,954.00	19,431,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,715,499.15	38,922,512.84
210201	Тэтгэврийн даатгал	4,655,708.47	27,273,374.31
210202	Тэтгэмжийн даатгал	538,344.14	3,032,854.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	430,672.93	2,322,306.17
210204	Ажилгүйдлийн даатгал	99,162.13	642,287.63
210205	Эрүүл мэндийн даатгал	991,611.48	5,651,689.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,788,578.00	29,462,243.00
210301	Гэрэл, цахилгаан	195,147.00	2,192,328.00
210302	Түлш, халаалт	8,426,880.00	23,398,637.00
210303	Цэвэр, бохир ус	166,551.00	3,871,278.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,553,000.00	12,482,300.00
210401	Бичиг хэрэг	610,000.00	1,703,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	1,000,000.00

Арвайхээр сумын 14-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	213,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,943,000.00	9,564,800.00
2105	Нормативт зардал	7,600,000.00	10,907,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	75,300.00
210502	Хоол, хүнс	0.00	10,380,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,400,000.00	451,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,763,000.00	4,098,000.00
210604	Урсгал засвар	4,763,000.00	4,098,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1,134,142.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,134,142.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	708,000.00	6,531,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	408,000.00	5,143,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	1,387,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,323,721.85	6,051,345.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	5,351,345.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	5,351,345.16
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,218,422.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,218,422.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,105,299.85	0.00
213502	Хаагдсан данс	0.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,105,299.85	0.00
213504	Хөрөнгийн	0.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГ ЭЭ (III)=(I)-(II)	47,469,000.00	20,840,000.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	47,469,000.00	20,840,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,469,000.00	20,840,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	47,469,000.00	20,840,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	47,469,000.00	20,840,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-47,469,000.00	-20,840,000.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	145325000.0	134001278.2	409,437,600.00	404,086,255.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145325000.0	134001278.2	409,437,600.00	404,086,255.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	145325000.0	134001278.2	408,737,600.00	403,386,255.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56800000.0	53834201.0	291,811,000.00	291,811,000.00
210101	Үндсэн цалин	42,100,000.00	42,648,800.00	193,410,100.00	223,950,457.00
210102	Нэмэгдэл	14,000,000.00	10,826,447.00	78,969,000.00	48,428,643.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт			0	0
210104	Урамшуулал	700,000.00	358,954.00	19,431,900.00	19,431,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7100000.0	6715499.2	41,501,900.00	38,922,512.84
210201	Тэтгэврийн даатгал	4,828,000.00	4,655,708.47	28,929,500.00	27,273,374.31
210202	Тэтгэмжийн даатгал	568,000.00	538,344.14	3,143,100.00	3,032,854.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	454,400.00	430,672.93	2,514,500.00	2,322,306.17
210204	Ажилгүйдлийн даатгал	113,600.00	99,162.13	628,600.00	642,287.63
210205	Эрүүл мэндийн даатгал	1,136,000.00	991,611.48	6,286,200.00	5,651,689.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9800000.0	8788578.0	32,234,200.00	29,462,243.00
210301	Гэрэл, цахилгаан	1,000,000.00	195,147.00	3,002,400.00	2,192,328.00
210302	Түлш, халаалт	7,900,000.00	8,426,880.00	24,901,800.00	23,398,637.00
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	166,551.00	4,330,000.00	3,871,278.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15473000.0	15473000.0	13,331,700.00	13,331,700.00
210401	Бичиг хэрэг	410,000.00	610,000.00	1,563,600.00	1,563,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	0	1,000,000.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал			213,900.00	213,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,863,000.00	14,863,000.00	10,554,200.00	10,554,200.00
2105	Нормативт зардал	7600000.0	7600000.0	10,907,400.00	10,907,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	200,000.00	75,300.00	75,300.00
210502	Хоол, хүнс			10,380,300.00	10,380,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,400,000.00	7,400,000.00	451,800.00	451,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30000000.0	24793000.0	4,098,000.00	4,098,000.00
210604	Урсгал засвар	30,000,000.00	24,793,000.00	4,098,000.00	4,098,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж			1,002,000.00	1,002,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	0.0	1,002,000.00	1,002,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18552000.0	16797000.0	13,851,400.00	13,851,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,252,000.00	16,497,000.00	12,463,600.00	12,463,600.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	300,000.00	1,387,800.00	1,387,800.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>			<b>700,000.00</b>	<b>700,000.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>			<b>700,000.00</b>	<b>700,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			700,000.00	700,000.00
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>145,325,000.00</b>	<b>134,001,278.15</b>	<b>409,437,600.00</b>	<b>409,437,600.00</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>105525000.0</b>	<b>100419700.2</b>	<b>373,105,400.00</b>	<b>373,105,400.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих			0	0
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	105,525,000.00	100,419,700.15	373,105,400.00	373,105,400.00
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>39800000.0</b>	<b>33581578.0</b>	<b>36,332,200.00</b>	<b>36,332,200.00</b>
320001	Орон нутгийн төсвөөс	39,800,000.00	33,581,578.00	36,332,200.00	36,332,200.00
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>			<b>207</b>	<b>207</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>			<b>1</b>	<b>1</b>
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	1	1
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>28.0</b>	<b>28.0</b>	<b>28</b>	<b>28</b>
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	21	21	21	21
620003	Үйлчлэх ажилтан	6	6	6	6
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>150.0</b>	<b>150.0</b>	<b>150</b>	<b>150</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>12802742.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>802742.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>802742.00</b>
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>670600.00</b>
210401	Бичиг хэрэг	-	140,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	530,600.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>0.00</b>	<b>132142.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	132,142.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>12000000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>12000000.00</b>
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		12000000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>802743.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>802743.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	662,743.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	140,000.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Арвайхээр сумын 14-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналт, анхан шатны баримтын хөтлөлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор аудитор Ө.Ринчинмядаг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.07-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Тус байгууллагын зорилго: Цэцэрлэг нь СӨН-ны хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх, хүмүүжлийн зөв хэвшил төлөвшүүлэх, асрах үүрэг бүхий хүмүүжил сургалтын байгууллага байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Тус газар нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газаргүй болно.

Тайлант онд тус байгууллагын дотоод хяналтын комисс нь нийт 17 үзүүлэлтээр дотоод хяналт шалгалтыг хийсэн бөгөөд холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арвайхээр сумын 14-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 421.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Тус байгууллагын хувьд тайлант онд Баянтээг ХК-ийн хөрөнгө оруулалтаар 12.0 сая төгрөгийн хайсан хашаа хийгдэж хөрөнгөд тусгасан. Мөн 2021 онд хөрөнгө оруулалтаар 8.25 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3.55 сая төгрөгийн тавилга, эд хогшил нэмэгдсэн байна. Бараа материалын хувьд өмнөх оны үзүүлэлтээс бусад хангамжийн материал 19.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 373.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 36.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Санхүүжилт өмнөх оноос 205 хувиар өссөн байна. Энэ нь тус байгууллага 2020 онд байгуулагдан 2 сар ажилласан, 2021 онд бүтэн жилээр жигдрэн ажиллаж эхэлсэнтэй холбоотой юм.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс нийт 409.4 сая төгрөгөөр санхүүжигдэн, 404.1 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 12.8 сая төгрөгийг бичиг хэрэг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тус тус зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тайлант онд бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 1,520.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 1,200.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж зориулалт зардлыг бусаар зарцуулсан зөрчил илэрсэн. Мөн дотоод хяналт сул байдалтай холбоотой гарсан зөрчлүүд нь аудитын хувьд гол онцлох асуудал байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус газар нь 2021 оны 1-4 улиралд нийт 149 мэдээллийг байршуулахаас 149 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтуудад тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд аудитад хамрагдаагүй болно.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй болно.

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

### 4.3 Албан шаардлага

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 1,520.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 1,200.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж зориулалт бусаар зарцуулсан байна.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

*Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй шинэ хөрөнгийг бараа материалд давхардуулан тоолсон, цагийн нэгдсэн бүртгэлийг цаг бүртгэл хөтлөх албан тушаалтан бүрэн хөтөлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын хөтлөлтөд тавих хяналт сул байна.*

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

*Анхан шатны баримтын хөтлөлтийг журмын дагуу хийх, дотоод хяналтыг сайжруулах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Арвайхээр сумын 14-р цэцэрлэг	2	2.72	0	0	0	0	1	2.72	1	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  Ө.РИНЧИНМЯДАГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 14-НЫ ӨДӨР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 02/2022/88/НА-СТАТЧУС/А/570353/85 Арвайхээр

Арвайхээр сумын 14 дүгээр  
цэцэрлэгийн эрхлэгч Ю.Мандах танаа  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хуруэнд тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудит хийхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 1,520.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 1,200.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж зориулалт бусаар зарцуулсан байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арвайхээр сумын 14 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Ю.Мандах, нягтлан бодогч Д.Оюундарь нарт даалгав.<sup>1</sup>

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН  
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР

О.БАТЖАРГАЛ  
Ө.РИНЧИНМЯДАГ



<sup>1</sup> Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.